

ИХЭРМӨРӨН АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/58/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа
Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com
Аудитор Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг	4
Аудитын гол асуудал	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
УИХ	Улсын их хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/135
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ П.АРИУНСАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгө данс 19,466.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Сургуулийн захирал Эрдэнэбулган сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг төлөвлөж, 98.4 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	172,999,324.26	203,131,352.26
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	19,466,133.00
31210	Төгрөг	-	19,466,133.00
31211	Төрийн сангийн харилцах	-	19,466,133.00
33	АВЛАГА	-	19,466,133.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	18,536,960.00
33500	Бусад авлага	-	3,807,400.00
33510	Байгууллагаас авах авлага	-	14,729,560.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	14,729,560.00
35100	Түүхий эд материал	172,999,324.26	165,128,259.26
35110	Тусгай зориулалттай материал	8,188,017.00	12,331,195.00
35130	Эм боох материал	4,005,350.00	9,551,495.00
35400	Хангамжийн материал	4,182,667.00	2,779,700.00
35410	Бичиг хэргийн материал	161,281,307.26	149,767,064.26
35420	Аж ахуйн материал	3,180,267.00	3,651,067.00
35440	Түлш, шатах тослох материал	76,438,334.65	70,980,234.65
35450	Барилгын засварын материал	9,995,000.00	36,589,760.00
35460	Хүнсний материал	22,828,665.00	4,912,725.00
35470	Бусад хангамжийн материал	13,564,810.00	4,036,145.00
35600	Мал амьтад	35,274,230.61	29,597,132.61
		3,530,000.00	3,030,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,328,065,529.36	2,357,964,445.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,328,065,529.36	2,357,964,445.99
39200	Биет хөрөнгө	2,269,731,445.89	2,300,930,362.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,134,061,298.00	2,134,061,298.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(152,845,420.44)	(217,372,574.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,746,018.00	14,746,018.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,746,018.00)	(14,746,018.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	168,506,539.18	218,992,114.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	(79,883,814.51)	(106,660,553.61)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	157,555,877.54	185,771,617.14
39208	Хуримтлагдсан элэгдэл	(61,900,310.15)	(78,420,388.58)
39214	Бусад үндсэн хөрөнгө	104,935,428.00	172,935,428.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(21,690,837.10)	(32,963,340.70)
39217	Ном	20,992,685.37	24,586,762.37
39300	Биет бус хөрөнгө	58,334,083.47	57,034,083.51
39301	Програм хангамж	7,287,000.00	7,287,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,634,916.53)	(5,934,916.49)
39303	Бусад биет бус хөрөнгө	55,682,000.00	55,682,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,501,064,853.62	2,561,095,798.25
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,501,064,853.62	2,561,095,798.25
51	Засгийн газрын хувь оролцоо	2,501,064,853.62	2,561,095,798.25
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,063,809,088.69	-
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,063,809,088.69	-
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	1,063,809,088.69
51200	Хуримтлагдсан үр дүн	1,069,569,102.58	1,129,600,047.21
51210	Өмнөх үеийн үр дүн	129,485,296.66	1,069,569,102.58
51220	Тайлант үеийн үр дүн	940,083,805.92	60,030,944.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	367,686,662.35	367,686,662.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,501,064,853.62	2,561,095,798.25

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,177,592,008.68	1,560,512,837.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,042,993,019.86	142,196,537.80
120	Нийтлэг татварын бус орлого	1,042,993,019.86	137,495,337.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	2,510,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,510,400.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,034,367,670.58	121,475,391.80
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	8,625,349.28	13,509,546.00
122	Тусламжийн орлого	-	4,701,200.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	4,701,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,134,598,988.82	1,418,316,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,075,279,300.00	1,264,170,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,264,170,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,075,279,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,933,588.82	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,933,588.82	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	54,386,100.00	154,145,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,386,100.00	154,145,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,189,831,959.24	1,500,121,893.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,189,831,959.24	1,500,121,893.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,155,471,437.24	1,438,992,322.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	830,969,893.00	998,832,487.00
210101	Үндсэн цалин	560,157,999.00	735,455,153.00
210102	Нэмэгдэл	216,779,670.00	228,199,064.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	54,032,224.00	35,178,270.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,990,100.00	126,874,700.00
210201	Тэтгэврийн даатгал	78,798,900.00	86,263,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,294,700.00	10,152,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,635,600.00	8,122,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,032,936.00	2,030,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,227,964.00	20,305,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,500,000.00	44,600,404.00
210301	Гэрэл, цахилгаан	10,000,000.00	13,631,654.00
210302	Түлш, халаалт	30,000,000.00	30,968,750.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	29,265,887.82	34,036,890.00
210401	Бичиг хэрэг	7,333,437.82	9,431,580.00
210402	Тээвэр, шатахуун	15,497,400.00	5,430,810.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	517,600.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,917,450.00	6,788,500.00
210408	Бараа материал акталсны зардал	-	12,386,000.00
2105	Нормативт зардал	30,476,005.00	54,331,956.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,823,400.00	1,744,467.00
210502	Хоол, хүнс	28,652,605.00	50,335,345.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,252,144.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,666,400.00	40,997,140.00
210604	Урсгал засвар	3,666,400.00	40,997,140.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,108,600.00	4,363,770.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,288,600.00	2,510,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	820,000.00	720,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,133,370.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	101,494,551.42	134,954,975.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	14,558,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,246,900.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	98,247,651.42	120,396,475.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,360,522.00	61,129,571.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,577,115.00	51,789,625.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,577,115.00	51,789,625.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,773,307.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,773,307.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,100.00	9,339,946.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,100.00	9,339,946.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	987,760,049.44	60,390,944.63
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	47,676,243.52	360,000.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	47,676,243.52	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	360,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	940,083,805.92	60,030,944.63

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН / төгрөгөөр /
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,136,772,988.82	1,420,826,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,510,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,510,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	2,510,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,510,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,136,772,988.82	1,418,316,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,075,279,300.00	1,264,170,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,264,170,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,075,279,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,107,588.82	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,933,588.82	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,174,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	54,386,100.00	154,145,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,386,100.00	154,145,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,101,004,388.82	1,374,090,567.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,101,004,388.82	1,374,090,567.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,066,984,581.82	1,310,660,151.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	828,969,893.00	1,002,639,887.00
210101	Үндсэн цалин	560,156,999.00	739,262,553.00
210102	Нэмэгдэл	214,780,670.00	228,199,064.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	54,032,224.00	35,178,270.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,977,500.00	126,874,700.00

210201	Тэтгэврийн даатгал		
210202	Тэтгэмжийн даатгал	78,798,900.00	86,263,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,294,700.00	10,152,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,635,600.00	8,122,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,659,000.00	2,030,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,589,300.00	20,305,400.00
210301	Гэрэл, цахилгаан	31,490,000.00	65,989,654.00
210302	Түлш, халаалт	10,000,000.00	13,631,654.00
210303	Цэвэр, бохир ус	19,990,000.00	52,358,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,500,000.00	-
210401	Бичиг хэрэг	18,345,567.00	-
210402	Тээвэр, шатахуун	497,600.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,000,000.00	-
210404	Ном, хэвлэл	517,600.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,181,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	822,567.00	-
2105	Нормативт зардал	9,326,800.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,101,700.00	43,673,480.00
210502	Хоол, хүнс	275,900.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	36,441,200.00	43,673,480.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,384,600.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,040,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	5,154,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	22,886,000.00	10,000,000.00
210702	Дотоод албан томилолт	746,400.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	746,400.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,698,100.00	5,053,770.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,878,100.00	2,510,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	820,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,543,370.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,615,421.82	56,428,660.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	43,213,060.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,615,421.82	13,215,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,019,807.00	63,430,416.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,236,400.00	54,090,470.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,236,400.00	54,090,470.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,773,307.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,773,307.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,100.00	9,339,946.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	10,100.00	9,339,946.00
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	35,768,600.00	46,736,133.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,768,600.00	27,270,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	35,768,600.00	27,270,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	35,768,600.00	27,270,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	35,768,600.00	27,270,000.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(35,768,600.00)	(27,270,000.00)
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	19,466,133.00
		-	-

20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	19,466,133.00
----	---	---	---------------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,063,809,088.69	409,439,860.35	87,732,098.66	1,560,981,047.70
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	41,753,198.00	41,753,198.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,063,809,088.69	409,439,860.35	129,485,296.66	1,602,734,245.70
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(41,753,198.00)	-	(41,753,198.00)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	940,083,805.92	940,083,805.92
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,063,809,088.69	367,686,662.35	1,069,569,102.58	2,501,064,853.62
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,063,809,088.69	367,686,662.35	1,069,569,102.58	2,501,064,853.62
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,063,809,088.69	367,686,662.35	1,069,569,102.58	2,501,064,853.62
19	Тайлант үеийн үр дүн	-	-	60,030,944.63	60,030,944.63
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,063,809,088.69	367,686,662.35	1,129,600,047.21	2,561,095,798.25

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,266,754,100.00	1,247,214,967.00	19,539,133.00	98.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,266,754,100.00	1,247,214,967.00	19,539,133.00	98.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,212,656,400.00	1,193,124,497.00	19,531,903.00	98.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	954,069,600.00	941,439,887.00	12,629,713.00	98.7
210101	Үндсэн цалин	722,872,900.00	678,062,553.00	44,810,347.00	93.8
210102	Нэмэгдэл	200,507,800.00	228,199,064.00	(27,691,264.00)	113.8
210104	Урамшуулал	30,688,900.00	35,178,270.00	(4,489,370.00)	114.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,258,700.00	119,258,700.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	81,095,900.00	81,095,900.00	-	100.0

Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгал	9,540,600.00	9,540,600.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,632,600.00	7,632,600.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,908,200.00	1,908,200.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	19,081,400.00	19,081,400.00	-	100.0
2105	Нормативт зардал	43,935,000.00	43,673,480.00	261,520.00	99.4
210502	Хоол, хүнс	43,935,000.00	43,673,480.00	261,520.00	99.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,393,800.00	5,053,770.00	6,340,030.00	44.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,583,400.00	2,510,400.00	73,000.00	97.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,810,400.00	2,543,370.00	6,267,030.00	28.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,999,300.00	83,698,660.00	300,640.00	99.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,783,700.00	70,483,060.00	300,640.00	99.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,215,600.00	13,215,600.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,097,700.00	54,090,470.00	7,230.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,097,700.00	54,090,470.00	7,230.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,097,700.00	54,090,470.00	7,230.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,266,754,100.00	1,266,681,100.00	73,000.00	100.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,264,170,700.00	1,264,170,700.00	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,264,170,700.00	1,264,170,700.00	-	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,583,400.00	2,510,400.00	73,000.00	97.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,583,400.00	2,510,400.00	73,000.00	97.2
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		19,466,133.00	19,466,133.00	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	76.00	76.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	43.00	43.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	32.00	32.00	-	100.0

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/ төгрөгөөр /		
			Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	154,145,600.00	144,805,654.00	9,339,946.00	93.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	154,145,600.00	144,805,654.00	9,339,946.00	93.9

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	154,145,600.00	144,805,654.00	9,339,946.00	93.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	68,962,800.00	61,200,000.00	7,762,800.00	88.7
210101	Үндсэн цалин	68,962,800.00	61,200,000.00	7,762,800.00	88.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,182,800.00	7,616,000.00	1,566,800.00	82.9
210201	Тэтгэврийн даатгал	6,244,300.00	5,168,000.00	1,076,300.00	82.8
210202	Тэтгэмжийн даатгал	734,600.00	612,000.00	122,600.00	83.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	587,700.00	489,600.00	98,100.00	83.3
210204	Ажилгүйдлийн даатгал	146,900.00	122,400.00	24,500.00	83.3
210205	Эрүүл мэндийн даатгал	1,469,300.00	1,224,000.00	245,300.00	83.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,000,000.00	65,989,654.00	10,346.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	16,000,000.00	13,631,654.00	2,368,346.00	85.2
210302	Түлш, халаалт	50,000,000.00	52,358,000.00	(2,358,000.00)	104.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	154,145,600.00	144,805,654.00	9,339,946.00	93.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	154,145,600.00	144,805,654.00	9,339,946.00	93.9
320001	Орон нутгийн төсвөөс	154,145,600.00	144,805,654.00	9,339,946.00	93.9
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1	1	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	31	31	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	31	31	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	31	31	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

1.6.1 Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургууль нь бага болон суурь, дунд боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.

Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

2022 онд “Сайн туршлагаа түгээн дэлгэрүүлэх, хамтран суралцах үйл явцыг идэвхжүүлэн, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээнд суурилсан хөгжил, оролцооны арга зүйг хэрэгжүүлнэ.” гэсэн зорилт тавьж ажиллажээ.

Сургуулийн захирал Эрдэнэбулган сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг төлөвлөж, 98.4 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
 - Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.
 - Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр”, “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал” баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
 - БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ыг 1 дүгээр, “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ыг 2 дугаар, “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг 3 дугаар, “тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ыг баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.

- БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал “Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай”
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал “ Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”
- БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу 2021 онд байгууллагын дотоод хяналтын багийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна.

Дотоод хяналтын багаас 2022 онд дотуур байр, үдийн цайны хоол үйлдвэрлэлийн орчин, анги танхимын цэвэрлэгээ, үйлчилгээ, орчны аюулгүй байдал, түрээсийн сурах бичгийн олголтод дотоод хяналтыг хэрэгжүүлж, сайжруулах шаардлагатай асуудлуудыг илрүүлэн зөвлөмж өгсөн байна.

Түүнчлэн 2022 онд сургуулийн захирлын тушаалаар шинээр гарсан дүрэм, журмуудын хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсөв санхүүг зарцуулах, түүнд хяналт тавих, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, шинээр гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий зөвлөл, ажлын хэсгүүдийг томилж ажиллуулсан байна.

Тус сургууль нь 2022 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулсан байна.

Эдгээр зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны дотоод хяналтын тогтолцоо бий болсон байна гэж үзлээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа БСШУС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг

өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 60,031.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт Б	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3
Мөнгөн хөрөнгө			
Авлага		19,466.1	19,466.1
Бараа материал		18,537.0	18,537.0
Үндсэн хөрөнгө	172,999.3	165,128.3	-7,871.0
Нийт хөрөнгө	2,328,065.5	2,357,964.4	29,898.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,501,064.8	2,561,095.8	60,031.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө / өмчийн дүн	2,501,064.8	2,561,095.8	60,031.0

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, эздийн өмч данстад өмнөх оноос нэмэгдэж, бараа материал данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 19,466.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Авлага дансны үлдэгдэл 18,537.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2022 оны 12 дугаар сард цахим дэлгүүрээс худалдан авахаар Ай ти зон ХХК, Саммит компьютер технологи ХХК-тай гэрээ байгуулж, төлбөр шилжүүлсэн боловч тайлант онд нийлүүлэгдээгүй компьютерын үнэ 14,729.6 мянган төгрөг, татварын албанд илүү шилжүүлсэн 3,807.4 мянган төгрөгийг тус тус авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.
3. Үндсэн хөрөнгө данс 29,898.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд батлагдсан төсвийн хүрээнд 27,270.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан, 2,550.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар хүлээж авсан, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 52,475.4 мянган төгрөг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 68,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн, үндсэн хөрөнгийн элэгдэл 120,396.5 мянган төгрөгөөр нэмж байгуулсан нь нөлөөлсөн байна.
4. Бараа материал дансны үлдэгдэл буурсан нь шалтгаан нь сургуулийн захирлын 2022 оны 12 сарын 30-ны өдрийн А/47 дугаар тушаалаар хуучирч, эвдэрсэн, ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй болсон хангамжийн материал, шүлхий өвчнөөр үхсэн мал акталсантай холбоотой.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд улсын төсвөөс санхүүжих зардлын дүнг 1,367,888.7 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

УИХ-аар 2022 оны төсвийг гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэхээр болсонтой холбоотойгоор байгууллагын төлөвлөж хүргүүлсэн дүнг 339,024.0 мянган төгрөгөөр бууруулан 1,028,864.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр төсвийн хуваарьт дараах байдлаар өөрчлөлт оруулсан байна. Үүнд: БШУС-ын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаал, 2022 оны 10 дугаар сарын 7-ний өдрийн А/258 дугаар тушаал, 12 дугаар сарын 30-ны өдрийн А/392 тоот тушаалаар тус тус өөрчлөлт оруулж, анхны баталсан төсвийг 235,206.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Ингэснээр нийт төсвийн зарлагыг 1,266,681.1 мянган төгрөгөөр, үүнээс 1,264,170.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэх, 2,510.4 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс 84,000.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, Эрдэнэбулган сумын ЗДТГ-т хүргүүлснийг сумын ИТХ-ын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолоор 240,350.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсвийн төслийг байр ашиглалтын тогтмол зардлаар тооцоолсныг байр ашиглалтын үйлчилгээний зардлаар нэмэгдүүлэн баталсантай холбоотой.

Эрдэнэбулган сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 01 тоот тогтоолоор тус сургуулийн төсөвт тодотгол хийж, 86,205.3 мянган төгрөгөөр бууруулан, 154,145.6 мянган төгрөгөөр баталсан нь төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, шимтгэлийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбоотой.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 1,264,170.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 154,145.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, нийт 1,418,316.3 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлого 2,583.4 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,510.4 мянган төгрөгийн төвлөрүүлж, 97.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын гүйцэтгэл 93.9 хувьтай, төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 9,339.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлсэн.

Улсын төсвөөс санхүүжих зардал 98.5 хувийн гүйцэтгэлтэй, зарцуулагдаагүй үлдэгдэл 19,466.1 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр байршиж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	3,524.20	3,524.20	-	100.00
2	80312-Сургалт семинар	1,762.10	1,762.10	-	100.00
3	81605-Эрүүл мэндийг дэмжих	4,052.80	4,052.00	0.80	99.98
4	81801-Үдийн цай хөтөлбөр	54,097.70	54,090.47	7.23	99.99
5	81806-Дотуур байрны үйлчилгээ	77,245.40	75,672.63	1,572.77	97.96
6	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	41,960.00	41,699.56	260.44	99.38
7	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	7,929.40	7,890.00	39.40	99.50
8	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	887,756.50	881,489.47	6,267.03	99.29
9	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	185,842.60	174,524.14	11,318.47	93.91
10	81848- Сурах бичгийн түрээс	2,583.40	2,510.40	73.00	97.17
Дүн		1,266,754.10	1,247,214.97	19,539.13	98.46
Орон нутгийн төсвөөс					

1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	76,000.00	75,989.7	10.3	100.0
2	80112-Нийтлэг үйлчилгээ	78,145.60	68,816.00	9,329.6	88.1
	Дүн	154,145.6	144,805.7	9,339.9	93.9
	Нийт дүн	1,420,899.7	1,392,020.6	28,879.1	98.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Ц.Мөнхтуяа гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Б.Мядагмаа хийж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,189,831.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 23,796.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 30 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 заалтад заасан Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулах заалтаас бусад заалтыг хэрэгжүүлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй асуудалд зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн ба тайлангийн 4.4.1 хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд 2022 онд нийт 151 мэдээлэл оруулахаас 5 мэдээллийн мэдээлэх хугацаа болоогүй, тайлант хугацаанд мэдээлэх 146 мэдээллээс 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Мэдээллийн агуулга, үнэн зөв байдлыг шалгахад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 330,864.5 мянган төгрөгийн 6 гүйлгээ, өмч, хөрөнгө, төсөв зарцуулахтай холбоотой 12,885.0 мянган төгрөгийн 2 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:”, 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;” заалт, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаа нь “нийцсэн ба зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 4 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг 100 хувь биелүүлж, 2 зөвлөмж хэрэгжилтийн шатанд байгаа ба шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлээгүй асуудалд зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн болно.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	4	-	3	-	72.5
Нийт дүн	4	-	3	-	72.5

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хувьсах зардлын нөхөн хангалтаар авч байгаа тоног төхөөрөмжийг хүлээн авч, орлогод авсан эсэх, сургуулийн үйл ажиллагаанд ашиглахаар худалдан авч байгаа сургуулийн удирдлагын цогц системийн ашиглалтад анхаарах шаардлагатай гэж үзлээ.

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор баталсан зардлын зориулалт, арга хэмжээ, нормативын дагуу төсвийг тооцон шинжлэхэд 260,504.1 мянган төгрөгийн санхүүжилтийн илүү тооцоо гарч байна. Энэ нь 2022 онд Засгийн газрын шийдвэрээр багш нарын болон үйлчилгээний ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлсэн, орон нутгийн төсвөөр санхүүжүүлэхээр баталсан үйлчилгээний ажиллагсдын цалин хөлсийг улсын төсвөөс олгосонтой холбоотой боловч төсвийн төлөвлөлтийг сайжруулахад холбогдох байгууллагууд анхаарах шаардлагатайг харуулж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 364,437.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс нийцлийн аудиттай холбоотой 343,749.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, аудитын явцад 16,880.8 мянган төгрөгийн алдааг залруулсан ба авлага үүсгэсэн асуудалд зөвлөмж өглөө.

Аудитаар дараах нягтлан бодох бүртгэлийн залруулгыг хийсэн болно. Үүнд:

- Иргэн, аж ахуйн нэгжээс өгсөн 2,151.2 мянган төгрөгийн хандивын орлогыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэснийг хандивын орлого дансанд бүртгэж залруулсан.
- Цахим дэлгүүрээс худалдаж авахаар 12 дугаар сард гэрээ байгуулж, төлбөр төлсөн боловч тайлант онд нийлүүлэгдээгүй 14,729.6 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг орлогод авсныг авлагаар залруулан бүртгэсэн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудалд дараах зөвлөмжийг өгсөн. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хувь хүний орлогын албан татварыг давхардуулан шилжүүлж 3,804.7 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 заалтад заасан “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.8 заалтыг хэрэгжүүлж, үүссэн авлагыг барагдуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
12 дугаар сард цахим дэлгүүрээс худалдаж авахаар гэрээ байгуулж, төлбөр төлсөн боловч тайлант үед нийлүүлэгдээгүй, биетээр байхгүй компьютер тоног төхөөрөмжийг орлогод авсан.	1	14,729.6	1	14,729.6	1	14,729.6		

Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Иргэн, аж ахуйн нэгжээс өгсөн хандивын орлогыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн	1	2,151.2	1	2,151.2	1	2,151.2		
Татварын албанд хувь хүний орлогын албан татварыг давхардуулан шилжүүлж авлага үүсгэсэн	1	3,807.4					1	3,807.4
Дүн	3	20,688.2	2	16,880.8	2	16,880.8	1	3,807.4

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил:								
Шилэн дансны цахим хуудсанд тайлант онд байршуулах 146 мэдээллээс хугацаанд хоцроож байршуулсан 10 мэдээлэл байна. Мэдээллийн агуулга, үнэн зөв байдлыг шалгахад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 330864.5 мянган төгрөгийн 6 гүйлгээ, өмч, хөрөнгө, төсөв зарцуулахтай холбоотой 12885.0 мянган төгрөгийн 2 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	343,749.5			1	343,749.5		
Дүн	1	343,749.5			1	343,749.5		



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 27 өдөр

№ 30/АД.060129/ХАА-2023/58
/ММ - СТН - ТЦЗ

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 146 мэдээлэл байршуулахаас 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 330,864,500 (Гурван зуун гучин сая найман зуун жаран дөрвөн мянга таван зуу)-н төгрөгийн 8 гүйлгээ, өмч, хөрөнгө, төсөв зарцуулахтай холбоотой 12,885,000 (Арван хоёр сая найман зуун наян таван мянга)-н төгрөгийн 2 шийдвэр, нийт 343,749,500 (гурван зуун дөчин гурван сая долоон зуун дөчин есөн мянга таван зуу)-н төгрөгийн 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр," 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр," гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг ханган, мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал П.Ариунсан, нягтлан бодогч Б.Энхжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Б.ДАВААНЯМ

